

МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

2026 ОНЫ 9-Р САР



01 / 04

2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ БА ХУУЛИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БҮЙ ЭСЭХ

01

2 их наяд төгрөгийн алдагдал

Тэнцвэржүүлсэн орлогыг 31.9 их наяд төгрөг, нийт зарлагыг 33.9 их наяд төгрөг байхаар тооцжээ.

02

Төсвийн тодотголын төсөл нь төсвийн суурь тэнцэлд тавигдах шаардлагыг хангаагүй

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцэл ДНБ-ий 2 ба түүнээс дээш хувийн ашигтай байх шаардлагад нийцээгүй.

03

Дагалдах өөрчлөлт нь хуулийн 6.5-тай зөрчилдөв

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцэлд тавигдах шаардлагыг бууруулан өөрчилж өргөн барьсан нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгтэй зөрчилдөж, төсвийн тогтвортой байдлын хамгаалалтыг сулруулж байна.

04

Дунд хугацааны төсвийн хүрээг төсөвтэй хамт өөрчилжээ

Энэ нь тогтвортой байдлын хуулийн зорилт, ач холбогдол болон төсвийн удирдлагын зарчимд сөргөөр нөлөөлөхөөр байна.



МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

2026 ОНЫ 9-Р САР



2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛД ТУССАН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, ИНФЛЯЦ БА ТАТВАРЫН ОРЛОГО

05

Урсгал зардал өсөж, хөрөнгө оруулалт буурав

2026 оны төсвийн тодотголоор урсгал зардлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг бууруулсан нь богино хугацааны эрсдэлийг бууруулах хэдий ч дунд, урт хугацаанд төсөв болон үнийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэж байна.

06

Цалин, тэтгэврийн өсөлт инфляцид дарамт үзүүлэхээр байна

Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, суурь тэтгэврийг нэмэх нь өрхийн орлого болон дотоод эрэлтийг дэмжих хэдий ч инфляцын дарамт үүсгэх эрсдэлтэй тул төсөв болон мөнгөний бодлогын уялдааг хангах шаардлагатай.

07

Татварын орлогын бууралтад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна

Зарим газрын тосны бүтээгдэхүүний гаалийн татварыг 0 хувь болгосон, том татвар төлөгчдийн ашиг, татвар ногдох орлого, төлөлт болон импорт буурсан.

08

2026 оны татварыг 2025 онд урьдчилан төвлөрүүлжээ

Аж ахуйн нэгж байгууллагын 2026 оны орлогын албан татварыг 2025 онд урьдчилан төвлөрүүлсэн нь тухайн онд төвлөрүүлэх орлогыг бууруулж, татварын орлогын бүрдүүлэлтэд нөлөөлсөн байна.



МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

2026 ОНЫ 9-Р САР



НОГДОЛ АШИГ БА ОРЛОГЫН ЭРСДЭЛ

09

1 их наяд төгрөгийн ногдол ашгаар татварын орлогын бууралтыг нөхөхөөр төлөвлөсөн

"Чингис хаан баялгийн сан нэгдэл" ХХК-ийн 2025 оны цэвэр ашгаас 1 их наяд төгрөгийн ногдол ашгийг төсөвт төвлөрүүлж, татварын орлогын бууралтыг нөхөхөөр төлөвлөсөн.

10

Ногдол ашгийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байна

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар дутуу төвлөрүүлсэн 15.6 тэрбум төгрөгийг бүрэн авах, эх үүсвэргүй 21.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг төлөвлөсөн зөрчлийг арилгах аудитын албан шаардлагыг хангалтгүй биелүүлснээс татварын бус орлого дутах эрсдэл үүссэн.

11

Зарлага 998 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ

Орлогыг нэмэгдүүлэхгүйгээр нийт зарлагыг 998 тэрбум төгрөгөөр өсгөж, төсвийн алдагдлыг 2 их наяд төгрөг (ДНБ-ий 2%)-т хүргэснээр орлого тасарсан тохиолдолд төсвийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэхээр байна.



МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

2026 ОНЫ 9-Р САР



ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮНГИЙН ХЭМЖИЛТ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЯНАЛТ

12

Хөтөлбөрийн үр дүнг хэмжих үзүүлэлт тусгаагүй

Төсвийн тодотголдд урсгал зардлын чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөрийн чанарын болон тоон үзүүлэлтийг тусгаагүй, шинэчлээгүй нь төсвийн тодотголын хэрэгжилт, зарцуулалтын үр ашгийг үнэлэхэд хүндрэл үүсгэхээр байна.

13

Шинээр нэмэх хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтөд тавих хяналт сул байна

Нэмж төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтөд тавигдах шаардлагад тавих хяналт хангалтгүй байгаа нь худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулахад сөргөөр нөлөөлж, санхүүжилтийн үр ашгийг бууруулах эрсдэлтэй.

Аудитын дүгнэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын хуулийн шаардлагыг хангах, цалин тэтгэврийн нэмэгдлийн инфляцад үзүүлэх нөлөөг тооцож төсөв ба мөнгөний бодлогыг уялдуулах, ногдол ашгийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, зарлагын үр дүнг хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлох, шинээр нэмэх хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвлөлтийн шаардлагыг нягтлахыг анхааруулж байна.